

ШАНХАЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ БАЙГУУЛЛАГА: МОНГОЛЫН ХАНДЛАГА

*С.Оюунцэцэг**

Аливаа орны хувьд олон талт яриа хэлэлцээний механизм нь өөрийн аюулгүй байдал, ашиг сонирхлоо хангах хэрэгсэл болдог.

Төв Азид ХАБГБ, Евроазийн эдийн засгийн нийгэмлэг, ТУХН гэх мэт олон байгууллага үйл ажиллагаагаа явуулж байгаа ч Монгол Улсын хамарч болох байгууллага нь ШХАБ болно. Гэхдээ ШХАБ-ын талаарх дэлхий нийтийн болоод манай улсын хандлага нэгдмэл ойлголтод хүрч чадаагүй хэвээр байна.

Монголын хувьд нэг хэсэг эрдэмтэд энэ байгууллагад элсэх нь зүйтэй, Монгол Улсын ирээдүйн хөгжлийг Төв Азитай холбон, ялангуяа эдийн засгийн хамтын ажиллагаанаас ашиг олох талаар авч үздэг байхад зарим нь явцуу ашиг сонирхлын үүднээс байгуулсан Орос, Хятадын, тэр дундаа Хятадын давамгайлал ихтэй механизмд элсэх нь дарамт шахалтад орох таагүй дүр төрхийг дагуулахвий хэмээх болгоомжлолыг үүсгэдэг болохоор элсэх хэрэггүй хэмээн үздэг. Ерөнхийдөө элсэх хэрэгтэй гэхээсээ илүү элсэх ёсгүй гэсэн байр суурь давамгайлдаг. Тэгвэл Монгол Улс тус байгууллагын гишүүн болох нь түүний эрх ашигт хэрхэн нийцэх вэ гэдэг асуудал гарна. Геополитикийн талаас нь авч үзвэл манай улс дэлхийн хүчирхэг хоёр улстай хиллэж, тэдний дунд хавчуулагдсан далайд гарцгүй орон гэдэг утгаараа энэ байгууллагын үйл ажиллагаанд тодорхой хэмжээгээр оролцож байхаас өөрцгүй байдалд хүргэж байдаг. Гэвч энэ байгууллагын төлөвшилт тодорхойгүйн сацуу манай хоёр хөрш улсын оролцоо давамгайлсан байгууллагад гишүүнчлэлтэй болох нь таагүй нөхцлийг үүсгэх бөгөөд энэ нь манай улсын үндэсний эрх ашигт төдийлөн нийцэхгүй нь мэдээж хэрэг.

Тиймээс ШХАБ-ыг үзэх Монгол Улсын үзлийг цаг хугацаагаар нь үечлэн үзвэл:

- а. 1996-2000 он
- б. 2001-2003
- в. 2004 оноос хойш өнөөг хүртэл

1996-2000 он. Энэ үед Шанхайн механизм нь зөвхөн хил хязгаарын маргаантай асуудлыг эв зүйгээр шийдэх явдлыг гол болгосон бөгөөд манай улсын хувьд хөрш улсуудтайгаа хилийн ямар нэгэн маргаангүй явдал нь түүнд элсэх шаардлагагүй гэж үзэхэд хүргэсэн. Энэ нь нэг талаас хилийн асуудлаар гаргасан уулзалтуудын үр дүн олонд нээлттэй бус, гуравдагч этгээдэд нууц, үйл ажиллагаа нь зөвхөн уулзалт төдийхнөөр хязгаарлагдаж байсан. Нөгөө талаас 1998 оны Алматын дээд хэмжээний уулзалтаас эхлэн

* С.Оюунцэцэг - Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн дэргэдэх Стратегийн судалгааны хүрээлэнгийн судлаач

аюулгүй байдал, эдийн засгийн асуудалд голлон анхаарах талаар гишүүд санал нэгдснээр¹ байгууллагын үйл ажиллагааны чиглэл хүрээгээ тэлэх болсон зэргээс үүдэн тус байгууллагын ирээдүй хэрхэн өөрчлөгдөж болох талаарх манай улсын төсөөлөл бүрхэг байсантай холбоотой. Түүнчлэн Төв Азийн улсуудын улс төрийн нөхцөл байдлын чиг хандлага тогтворжоогүй, төр улсаа гүйцэд тохинуулж амжаагүй нь ардчиллын замыг сонгоод удаагүй байгаа Монголыг уг чуулгад элсэх эсэх тухай асуудлыг судлахад хүргэсэн.

Монгол Улсыг тус байгууллагын гишүүн болгох сонирхол Орос, Хятад хоёрт хоёуланд нь байдаг. Орос, Хятадын зүгээс хоёр талын уулзалтын хүрээнд уг байгууллагын талаарх мэдээллийг манай улсад өгч байв. 2000 оны 11 дүгээр сард ОХУ-ын Ерөнхийлөгч В.В.Путин Монгол Улсад төрийн айлчлал хийх үеэрээ гаргасан “Улаанбаатарын Тунхаглал” Шанхайн чуулга уулзалтын зорилго, зорилт, үйл ажиллагааны тухай мэдээлэл хийсэн² нь Монголыг уг чуулгад гишүүнчлэх сонирхлын нэг илрэл байсан юм. Сонирхолтой нь Монгол-Хятадын албан ёсны баримт бичгүүдэд ШХАБ-ын талаар ерөөсөө дурдагдаагүй ч Хятадын зүгээс албан бус шугмаар уг байгууллагад элсэх талаарх саналыг тавьдаг нь нэгдүгээр суваг гэхээсээ илүү хоёрдугаар сувгийн яриа хэлэлцээгээрээ дамжуулан Монголыг тус чуулгад элсүүлэх сонирхолтойг харуулж байв. Энэ нь хоёр орны харилцааны жинхэнэ үндэс болсон иргэд хоорондын харилцаа хоёр талд бие биеийн талаар бүрхэг ойлголт, төсөөлөлтэйн дээр түүхийн үүднээс хандах явдал түгээмэл байгаатай холбоотой байж болох юм. Өөрөөр хэлбэл хоёр орны харилцааны суурь бэхжээгүй үед улс төрийн түвшиндээ өөрийн оролцоо ихтэй бүс нутгийн механизмд тус улсыг татан оролцуулах хүчин чармайлтыг тавибал “Хятадын аюул” гэсэн иргэдийн хардлагыг хэт төрүүлсэн эмзэглэл үүсгэхвий гэсэн болгоомжлол нь тэднийг улс төрийн түвшинд асуудлыг тавихад тээг болдог болохоор хоёр орны албан ёсны түвшинд тавигддаггүй, баримт бичгүүдэд ч тусгагддаггүй бололтой.

2001-2003 он. 2001 онд “Шанхайн чуулга”-ыг ШХАБ хэмээх бүс нутгийн байгууллага болгон өргөжүүлснээр энэ байгууллагын үйл ажиллагаа улс төр, аюулгүй байдал, эдийн засаг гэх мэт олон салбарыг хамрах талаар тусгасан ч байгууллагын зорилго тодорхойгүй хэвээр байв. Энэ үед Монгол Улсын зүгээс тус байгууллагад элсэх асуудлыг албан ёсны хэмжээнд судлах шатандаа яваагаар тайлбарлан байв.

Ерөнхийдөө ШХАБ-ыг хоёр их гүрэн ОХУ, БНХАУ-ын харилцаа, ашиг сонирхлын нийцлээс илт хамаарах эмзэг бүтэцтэй³ механизм гэдэг. Хэрэв хоёр хөршийн харилцаанд тааламжгүй байдал үүсвэл ШХАБ-ын үйл ажиллагаа зогсонги байдалд орно. Гутранги талаас харвал суурь нь бэхжээгүй байгууллага татан буугдахад хүрч мэдэх юм. Тэгвэл Монголын хувьд өөрийгөө тойрсон геостратегийн орчинд үүсэн бүрэлдсэн шинэхэн байгууллагын олон улсын харилцаанд гарч байгаа өөрчлөлтүүдэд хандах

хандлага ямар байх, ялангуяа Орос, Хятадын хандлагыг ажиглах, түүний зэрэгцээ хүчний тэнцвэрийг хадгалах зорилготой цэрэг-улс төрийн эвсэл хэлбэрийн байгууллага болох уу аль эсвэл хамтын аюулгүй байдлын үзэл баримтлал, хамтын ажиллагааг удирдлага болгосон нээлттэй байгууллага болох уу гэдгийг харгалзах явдал хамгийн чухал асуудал байсан. Хэрэв ШХАБ цэрэг-улс төрийн эвсэл хэлбэрийн байгууллага болвол Гадаад бодлогын үзэл баримтлалд “цэргийн эвсэл холбоонд нэгдэхгүй”,⁴ хэмээн хуульчилсан манай улсын бодлогод нийцэхгүй.

Нөгөөтэйгүүр 2001 оны 9 дүгээр сарын 11-ний үйл явдлын дараах их гүрнүүдийн Төв Ази дахь ашиг сонирхлын идэвхжил нэмэгдэж эдгээр улсууд тус бүс нутагт хамтран ажиллах уу аль эсвэл сөргөлдөх үү гэдэг асуудал тулгарсан. Хэрэв манай улс тус байгууллагын гишүүн болсон үед талууд хоорондоо сөргөлдвөл манай орны гуравдагч улстай харилцах харилцаанд, ялангуяа Гадаад бодлогын үзэл баримтлалд эрэмблэсэн хоёр дахь чиглэлд дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудтай харилцах, тэр дундаа АНУ-ын бодит сонирхлыг өөрийн улсад бий болгоход бэрхшээл сорилт учирч болох юм.

Өөрөөр хэлбэл үзэл бодлын зөрөөтэй байр суурь өнөөгийн олон улсын харилцаанд гарч буй зарим үйл ажиллагаан дээр тодорхой харагдаж байдаг билээ. Ялангуяа АНУ-аас Ирак уруу цохилт өгөхөд Монгол Улс АНУ-ыг дэмжиж терроризмын эсрэг холбоотны эвсэлд нэгдэж буйгаа албан ёсоор илэрхийлж байхад хоёр хөрш энэ тал дээр манайхаас тэс өөр байр суурьтай буюу Ирак руу цохилт өгсөн явдал нь АНУ-ын алдаа гэх мэтээр шүүмжилсэн мэдэгдэлийг хийж байсан. 2003 онд Орос, Хятадын зүгээс зөвхөн НҮБ-ын Аюулгүйн Зөвлөл Иракийн сэргээн босголтын талаар шийдвэр гаргах, Аюулгүйн Зөвлөлийн тогтоолын дагуу Иракийн асуудлыг зохицуулах явдлыг чухалчлан үзэж байв.⁵ Үүнээс үзэхэд цаашид дэлхий дээр болж буй үйл явцын талаар баримтлах манай бодлого хоёр хөршийн бодлоготой зөрөхгүй гэх баталгаа муутай байгаа байдал нь манай улсад ямар нэгэн дарамт шахалт ирж болох талтайг харуулж байгаа юм.

Энэ мэтээр манай улс ШХАБ үүсэн бий болсон эхний үед тус байгууллага АНД-н аюулгүй байдлын тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болон хөгжих магадлал хэр байгаа, үйл ажиллагааны цаашдын чиг хандлагыг судлах зэрэгт дүгнэлт хийхэд түлхүү анхаарч байв.

Энэ үед Монгол Улсыг ШХАБ-ын гишүүн боллоо гэх мэтээр гадаадын хэвлэл мэдээлэл, интернетээр ихэд цацагдахын зэрэгцээ гишүүн орнуудын төрийн тэргүүн нарын дээд хэмжээний уулзалтад ерөнхийлөгчийн хэмжээнд оролцох гэж буй талаар ч ташаа мэдээл гарч байсан нь Монголыг гишүүнчлэх сонирхол хоёр хөршид их байсантай холбоотойгоор тайлбарлаж болох юм.

2004 оноос хойш өнөөг хүртэлх. 2004 онд Гадаад хэргийн сайд нарын ээлжит хуралд Монгол Улсын Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун зочноор оролцож байсан бол Монголын хувьд энэ нь цаашид ШХАБ-ын ажиглагч гишүүн болох эхлэл болсон. Манай улсын хувьд ШХАБ-д ойр байж, түүний үйл ажиллагаатай сайтар танилцахын тулд зочин юмуу аль эсвэл ажиглагчийн хэмжээнд үйл ажиллагаанд нь оролцох шаардлага үүсэн бий болсон. Гэвч энэ үед ШХАБ-ын дэргэд ажиглагч улсуудыг элсүүлэх эрх зүйн орчин бүрэлдэн тогтсон нь Монголыг анхны ажиглагч гишүүн болоход нөлөөлсөн.

Энэ үед Оросын зүгээс Монгол Улсыг ШХАБ-ын гишүүн болгох сонирхол нь идэвхжсэн хэмээн үзэж болох юм. ОХУ-ын Гадаад хэргийн сайдын айлчлалын үеэр ШХАБ-ын үйл ажиллагаанд Монгол Улс аль нэгэн хэлбэрээр оролцох боломжийг хэлэлцэх зорилготой зөвлөлдөх уулзалтуудыг тогтмол зохион байгуулж байхаар талууд тохиролцов.

Нөгөөтэйгүүр ШХАБ-ын хүрээнд улс төр, аюулгүй байдлын сацуу худалдаа-эдийн засаг, бүс нутгийн хамтын ажиллагааны асуудлыг хамруулан авч үзэх хандлагатай болж байгаа нь Монгол Улсын сонирхлыг зүй ёсоор татах болсон⁶ зэрэг нь ажиглагч гишүүний статусыг авахад дэм болов.

Ийнхүү 2004 онд болсон Ташкентын дээд хэмжээний уулзалтаар ажиглагч гишүүн болохын зэрэгцээ Ерөнхийлөгчийн бие төлөөлөгч оролцсон явдал ШХАБ-ыг үзэх Монголын бодлогод өөрчлөлт орсныг харуулсан үйл явдал болов. 2005, 2006 оны ШХАБ-ын төрийн тэргүүн нарын уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр, Засгийн газрын тэргүүн нарын уулзалтад 2005 онд Ерөнхий сайд Ц.Элбэгдорж, Гадаад хэргийн сайд нарын уулзалтад Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил нар оролцсон нь ШХАБ-д ач холбогдол өгч байгаагаа тодотгов. Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил Астанад болсон ШХАБ-ын Гадаад хэргийн сайд нарын уулзалтад оролцохдоо “ШХАБ-ын хүрээнд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааг хөгжүүлэх сонирхолтой байгаагаа илэрхийлсэн”,⁷ мөн түүнчлэн Ерөнхий сайд Ц.Элбэгдорж эдийн засгийн харилцааг өргөтгөх, түүн дотроо дэд бүтцийн төслүүдэд идэвхтэй оролцох, эрчим хүч, зам тээврийн салбар дахь хөрөнгө оруулалтыг дэмжих чиглэлд ажиллах нь Монгол Улсын хувьд харилцан ашигтай хамтын ажиллагаа байхыг онцлон тэмдэглэсэн байдаг.⁸

2005 онд Казахстаны Алматы хотноо болсон дээд хэмжээний уулзалтад Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр оролцохдоо “Монгол Улс ШХАБ-тай худалдаа, эдийн засгийн тэр дундаа дэд бүтцийг хөгжүүлэхэд чиглэсэн хамтын төслүүд хэрэгжүүлэх”-ийг⁹ онцлон тэмдэглэж байсан бол 2006 оны уулзалтад хэлсэн үгэндээ “ажиглагч болон гишүүн орны хамтын ажиллагааг улам гүнзгийрүүлэх, ШХАБ-ын талаарх мэдээллийг чөлөөтэй авахад бүтцэд төлөөлөлтэй болгох, эдийн засгийн салбарт хамтран ажиллах сонирхолтой байгаагаа илэрхийлсэн”¹⁰ нь Монголын олон талт гадаад бодлогод ШХАБ-тай харилцах сонирхол бий болсны илрэл хэмээн

дүгнэж болох юм. Нөгөөтэйгүүр ЗХА болон Төв Азийн бүс нутгийн олон талт үйл явцад оролцон хамтын ажиллагаагаа хөгжүүлэхэд бодитой хувь нэмэр оруулах чиглэлийг баримтлах бодлого¹¹ Төв Азийн чиглэлд хэрэгжихдээ улс төрийн хүрээнд гэхээсээ илүү эдийн засгийн салбарт түлхүү хөгжих нь эндээс харагдаж байна.

Гэвч ажиглагч орнуудын хувьд ШХАБ-ын төсөл, хөтөлбөрүүдэд хамрагдах эрх зүйн орчин нь бүрэлдэн тогтоогүй явдал Монголыг ШХАБ-ын гишүүн улс болгох шалаанд оруулж байгаа хэрэг юм. Тэгвэл улс төрийн аюулгүй байдлын үр дагаварыг тооцохгүйгээр зөвхөн эдийн засгийн ашгийг харан тус байгууллагын гишүүн болох нь Монгол Улсад их эрсдлийг бий болгоно. Эндээс ШХАБ Монгол Улсын ашиг сонирхлыг илэрхийлэгч байгууллага мөн үүгэдэг асуудал гарна.

ШХАБ уу аль эсвэл эрх ашиг уу?

Зарим орны эрдэмтэд ШХАБ-д Монгол Улс тэргүүлэх үүрэгтэй оролцох боломжтой хэмээн үздэг. Хоёр их хөршийн манлайллын дор байдаг энэ байгууллагад тэргүүлэх үүрэг гүйцэтгэнэ гэдэг нь үнэн хэрэгтээ боломжгүй зүйл. Эхэн үедээ ОХУ-ын хувьд ШХАБ-д төдийлөн ач холбогдол өгөхгүй, түүнийг “хилийн асуудлаа шийдэх явдлаар үүрэг нь хязгаарлагдах төдийхнөөр төсөөлж байсан”-аас¹² харахад Төв Ази дахь Оросын ашиг сонирхлын хэрэгсэл нь ТУХН болж байв. Гэхдээ хилийн маргааныг эцэслэн шийдэж чадсан ололт амжилт нь түүний ШХАБ-д хандах хандлагыг өөрчилж, зорилго нь тодорхой бус байсан байдлыг арилгаж, түүнийг “бүс нутгийн хамтын ажиллагааны шинэ хэв загвар”¹³ гэж үзэхэд хүргэсэн. Тэгвэл манай урд хөрш Хятадын хувьд ШХАБ-ыг нэг талаас Хятадын бүрэн бүтэн байдлыг хадгалах механизм, нөгөө талаас НАТО-ийн өргөжилтийн эсрэг Оросуудын ёс төдий байгууллага гэх мэтээр өөр өөр өнцгөөс түүнийг харж байсан. Нэг хэсэг хүмүүс Хятадын Төв Ази дахь улс төр, эдийн засгийн сонирхлын хөшүүрэг ч гэж үзэх хандлага гарч байсан нь уг байгууллагыг үүсгэгч Хятадын үзэл дотооддоо зөрчилтэй байгааг харуулсан. Хятадын гадаад бодлогын өнөөгийн нөхцөл байдлыг шинжлэн харвал ШХАБ-ыг нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, Төв Ази дахь улс төр, эдийн засгийн ашиг сонирхлыг хэрэгжүүлэгч хүчин зүйлээ болгон ашиглаж буй нь тодорхой харагддаг. Энэ талаар Жефферсон Турнер “ШХАБ-ын Дүрэм нь АНУ тэргүүтэй хоёр талын холбоо, аюулгүй байдлын бусад харилцааг эсэргүүцсэн бүс нутгийн аюулгүй байдалд олон талт харилцааг дэмжих Бээжингийн аюулгүй байдлын шинэ үзэл баримтлалыг хүчин төгөлдөр болгож байна”¹⁴ гэснийг өөрийн өгүүлэлдээ иш татсан байна. Эндээс харахад энэхүү үйл ажиллагаа нь Хятадын дипломат бодлогыг ялалтад хүргэв. Түүнчлэн “олон улсын харилцааны олон туйлт тогтолцоог буй болгох”, “аюулгүй байдлын шинэ тогтолцоог буй болгох” гэх мэт үг

хэллэгүүд нь Хятадын гадаад бодлогын түгээмэл үг хэллэгийн дээр Орос-Хятадын хоёр талын хамтарсан хэд хэдэн баримт бичигт тусгалаа олсон¹⁵ нь ШХАБ дахь Хятадын хүчин зүйлийг дөвийлгөсөн зүйл юм.

Ийнхүү ШХАБ дахь Орос, Хятадын ашиг сонирхлын давамгайлал нь Монголын ашиг сонирхлыг хязгаарлахад хүргэж мэдэшгүй. Өөрөөр хэлбэл хоёр их гүрний дунд бид өөрсдийн гэсэн бодлогоо алдах эрсдэлтэй. Тэгвэл ШХАБ-тай хамтран ажиллах нь Монголын ашиг сонирхол юу вэ гэдэг асуудал гарч ирнэ.

Аливаа орны (том, жижиг ямар ч улс) ашиг сонирхол нь тусгаар тогтнол, улс орныхоо хөгжил, дэвшлийг хангах нөхцөл нь болж байдаг. Тэгвэл бүс нутгийн хамтын ажиллагааны хүрээнд Монголын хувьд ашиг сонирхлоо хэрхэн бүрдүүлж болох асуудал тулгарна. 1994 оны Гадаад бодлогын үзэл баримтлалд “олон тулгуурт, нээлттэй гадаад бодлого явуулах”-аар тусгаснаар олон талт хамтын ажиллагааг дэмжсэн явдал болов. Тэгэхдээ улс гүрэнтэй сөргөлдөхгүйн сацуу үндэсний ашиг сонирхлоо ямагт дээдлэхийг чухалчлан үзсэн.¹⁶

Хэдийгээр Монголын гадаад бодлогод олон талт харилцааг дэмжих явдал нь илүүтэй байгаа ч ШХАБ-ын хэтийн төлөвшилтийн тодролтыг бий болтол ШХАБ-тай гишүүний хүрээнд хамтран ажиллах гэхээсээ илүү түүний гишүүдтэй хоёр талт харилцааныхаа ашигт чанарыг дээшлүүлэх замаар хамтын ажиллагаагаа хөгжүүлэх нь “үндэсний ашиг сонирхолд нийцсэн, тэнцвэртэй, олон тулгуурт гадаад бодлого”-ыг хэрэгжүүлэх цөм нь болох юм.

Монголыг ШХАБ-д гишүүнчлэхийн цаад учир

Нэгдүгээрт, Монгол Улсын хувьд 1990-ээд оноос эхлэн олон тулгуурт нээлттэй гадаад бодлого баримтлах болсноор дэлхийн өндөр хөгжилтэй улс орнуудтай харилцах, тэр дундаа АНУ-тай харилцах харилцаа улам гүнгийрч буй явдал Орос, Хятадын сонирхлыг татах болсон. Ялангуяа Хятадын хувьд НАТО Оросын нөлөөнд байсан улс орнууд руу хүрээгээ тэлж улам бэхжиж, Хятад АНУ-тай сайн харилцаатай улс орнуудын хүрээлэлд орох айдасыг арилгахын тулд Монголыг гишүүн болгох сонирхол нь нэмэгдсэн. 2003 оны 5 дугаар сард БНХАУ-ын дарга Ху Жинтао Монгол Улсад төрийн айлчлал хийх үеэр гаргасан Хамтарсан мэдэгдэлд “...гадаадын цэрэг зэвсгийг нутаг дэвсгэртээ байрлуулахгүй байх Монгол Улсын чиг шугамыг Хятадын тал дэмжиж байгаагаа илэрхийлсэн”-ий¹⁷ цаад утга нь Хятадын хувьд Америкийн цэргийн хайчинд орсон явдал хүрээгээ тэлж, яваандаа Америк Монголын харилцаа улам гүнзгийрэн хөгжснөөр Америкийг дэмжигчдийн тойрон хүрээллийн аюулд орохоос сэрэмжилсэн байдал юм. Ялангуяа Хятадын хувьд Монгол-Америкийн цэргийн харилцаанд ихээхэн анхаарал хандуулдаг явдал нь ШХАБ-аар дамжуулан Монгол дахь Америкийн нөлөөг сааруулах сонирхол давамгайлдаг болов уу.

Хоёрдугаарт, Хятадын үндсэн ашиг сонирхлын нэг нь ирээдүйн хэт их гүрэн болохын тулд хил залгаа оршин буй хөрш улсуудын эдийн засгийн ашиг бүхий стратегийн нөөцөд өөрийн хөрөнгө оруулалтын давамгайлалыг бий болгох явдал. Тиймээс өдгөө энэхүү бодлогоо хэрэгжүүлэхдээ ШХАБ-ын нөлөөг түлхүү ашиглах, тэгэхдээ түүний гишүүдтэй эдийн засгийн салбарт хоёр талын хамтын ажиллагааг илүүтэй дэмжих бодлогыг барьж байна. Тухайлбал Хятад, Казахстаны хоёр талын эдийн засгийн харилцаа аажмаар өсөн нэмэгдэж байгаа бөгөөд ирэх дөрвөн жилд хоёр талын худалдаа 10 тэрбум ам.долларт хүрч магадгүй.¹⁸ Өөрөөр хэлбэл эдийн засаг нь дорой орнуудын орон зайд тоглох сонирхлын идэвхжил нь Монголыг тойрон өнгөрөхгүй бөгөөд ингэснээрээ түүнийг ШХАБ-д татан оруулах, худалдаа, хөрөнгө оруулалтад гүйцэтгэдэг тэргүүлэх үүргээ улам нэмэгдүүлэх, улмаар эрчим хүч, эдийн засгийн талаарх сонирхол нь барууншаа ШХАБ, өмнөшөө АСЕАН болж өөрийгөө тойрон хүрээлүүлсэн эдийн засгийн хүчирхэг нэгдлийг хөгжлийн гол хөшүүргээ болгох явдал мөн. Тэгвэл бид ШХАБ-д ямар оролцоотой байх вэ?

ШХАБ дахь оролцооны хэлбэр Монголын сонголт

Аливаа нэг улс олон улсын болон бүс нутгийн байгууллагатай хамтын ажиллагаагаа хөгжүүлэхдээ гишүүн, ажиглагч, зочин зэрэг түгээмэл хэлбэрээс гадна зөвлөлдөх түнш, яриа хэлэлцээний түнш гэх мэт олон хэлбэрээр оролцдог. Тэгвэл Монголын хувьд ШХАБ-тай харилцахад бодлогын ямар сонголт ашигтай вэ?

а.Гишүүн

Ямар ч улсад бүс нутгийн болоод олон улсын олон талт хамтын ажиллагаанд оролцоход эерэг, сөрөг хоёр хүчин зүйлийг дагуулж байдаг нь бичигдээгүй хууль юм. Гэхдээ сөрөг талыг нь аль болохоор багасгах, аль эсвэл өөрийн эрх ашигт үл харшлах оролцооны аль нэгэн хувилбарыг сонгох явдал байдаг. Тэгвэл Монгол Улсын хувьд ШХАБ-ын гишүүн болоход эерэг гэхээсээ илүү сөрөг хүчин зүйлүүд давамгайлдаг. Тухайлбал: ШХАБ дотроо зөрчилтэй, нэгдмэл санаа зориггүй байгаагаас үүдэн төлөвшилт тодорхойгүйн дээр бүс нутагт аюулгүй байдлын болон эдийн засгийн хувьд ямархуу үүрэг гүйцэтгэх зэрэг нь бүрхэг байна. 2005 оны 6 дугаар сард Төв Азиас цэргээ гаргахыг АНУ-д ШХАБ-ын гишүүд нийтээрээ уриалсан ч Кыргызстаны Ерөнхийлөгч Курманбек Бакиев Америкийн цэргт зориулж шинэ бааз байгуулах тухайгаа мэдэгдэн амлалтаасаа буцсан.¹⁹ Энэ нь тус байгууллагыг “бүс нутгийн хүчирхэг механизм” болгохоосоо илүү “цаасан бар” гэгдэхэд хүргэж мэдэх юм. Цэргийн салбарын хамтын ажиллагааны эрчимжилт нэмэгдсэн. 2007 оны 8 дугаар сард “Энхийн элч 2007” нэртэй терроризмын эсрэг цэргийн хээрийн хамтарсан сургуулийг ШХАБ-ын хүрээнд зохион байгуулсан төдийгүй тэд гадны ажиглагчдыг оролцуулахыг

хүсээгүй нь зөвхөн Орос, Хятадын хоёр талын цэргийн сургуулийн үргэлжлэл өргөжснийг харуулав. Нөгөөтэйгүүр уг цэргийн хээрийн сургуулийг гуравлагч орны эсрэг чиглэгдээгүй гэсэн хэдий ч ажиглагчдыг оролцоулахгүй хаалттай байсан нь ШХАБ-ын ирээдүйг НАТО-ын эсрэг цэргийн эвсэл гэгдэхэд хүргэж мэднэ. Тэгвэл манай улсын хувьд үндэсний эрх ашигт нийцсэн оролцооны өөр хэлбэрийг сонгох асуудал гарч байна.

б. Ажиглагч

ШХАБ-ын дэргэдэх ажиглагчийн статусын тухай журам ёсоор ажиглагчид нь зөвхөн бэлэгдлийн шинж чанартай бөгөөд ШХАБ-аас хэрэгжүүлж буй бүс нутгийн хамтын ажиллагааны төслүүдэд хамрагдах боломжгүй. Тэгвэл бидний гишүүнчлэсэн ажиглагчийн статус бидэнд ашиг авчиргахгүй нь. Бид ажиглагчаар үлдэх үү, ажиглагчаасаа татгалзах уу аль эсвэл өөр сонголт хайх уу гэдэг асуудал тулгарна. Өнөөдөр бид ШХАБ-ын ажиглагчийн статусаасаа шууд татгалзах боломжгүй. Тиймээс анхны ажиглагч гишүүн болохын хувьд ШХАБ-ын төсөл хөтөлбөрүүдэд хамрагдахын тулд ШХАБ-ын дэргэд аюулгүй байдлын АРФ-тай төстэй байгууллага болон эдийн засгийн бүсийн чуулгыг үүсгэн байгуулах санаачлагыг гарган зөвшилцөлд хүргэх ба түүндээ ардчилалын үнэт зүйлсийн нийтлэг бүхий улс орнуудын төлөөллийг оруулахад анхаарах. Ялангуяа эдийн засгийн хамтын ажиллагааг эрчимжүүлэх “Бүс нутгийн эдийн засгийн форум”-ыг үүсгэхэд идэвхтэй ажиллах. Хэрэв энэхүү санаачлага дэмжигдэн ШХАБ-ын дэргэд иймэрхүү байгууллага бий болон түүнд манай улс оролцоотой болвол ажиглагчийн статус хүчингүй болно. Өөрөөр хэлбэл ШХАБ-ын дэргэдэх ажиглагчийн статусын тухай журмын 14-т “харилцах хэлбэр өөрчлөгдсөн тохиолдолд тэдгээрийн ажиглагчийн статус өөрөө хүчингүй болно”²⁰ гэж заасанчланаар ажиглагчийн статусаасаа татгалзаж болох бөгөөд энэ нь идэвхтэй дипломат бодлого байх болно. Гэвч энэ нь ихээхэн цаг хугацаа шаардах нарийн ажил боловч энэ талаарх дэмжлэгээ эхлээд ажиглагч орнуудын зүгээс авах, дараа нь Орос, Хятадын дэмжлэгийг авах замаар урагшуулах нь манай тэнцвэртэй гадаад бодлогод нийцнэ.

Гэхдээ бидний хувьд эдгээр хүчин зүйлийг дэмжигдэх хүртэл ажиглагчийн хэмжээнд үйл ажиллагаанд нь оролцоход хангалттай.

в. Яриа хэлэлцээ болон зөвлөлдөх түнш

Хэрэв ШХАБ-ын ажиглагчийн институт бүрэн утгаараа бүрэлдэн тогтохгүй энэ хэвээрээ яваад байх юм бол Монгол Улс түүний ажиглагч биш зөвхөн жил тутмын дээд хэмжээний уулзалтад оролцогч идэвхгүй субъект болон хувирна. Тиймээс бүс нутгийн болон олон улсын бусад байгууллагууд ШХАБ-ын яриа хэлэлцээний юм уу аль эсвэл зөвлөлдөх түнш болвол ШХАБ-тай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх Монголын бодлогод эерэг нөлөөтэй. Гэвч Монгол Улс эдийн засгийн хөгжил сул, олон улсын

харилцаанд жин нөлөө багатай болохын хувьд ШХАБ-тай яриа хэлэлцээ болон зөвлөлдөх түншийн хэлбэрээр харилцах боломжгүй юм.

Дүгнэлт

ШХАБ-ыг үзэх Монголын үзэл нь жилээс жил ирэх тусам өөрчлөгдөж түүнд хандах хандлага нь нааштай болж байна.

Монгол Улсын хувьд өөрийн улсын хилийн баруун талд аюулгүй байдлыг сахин хамгаалах олон талт хамтын ажиллагааны байгууллага байгуулагдсан нь бүс нутагтаа тогтвортой байдлыг хадгалах гэсэн манай улсын бодлогод нийцэж байгаа ч уг байгууллага нь аюулгүй байдал, эдийн засгийн гэхээсээ илүү цэрэг улс төрийн ашиг сонирхолд тулгуурласан бүс нутгийн байгууллага болох магадлал гарч байгаа явдал нь цэргийн эвсэл холбоонд нэгдэхгүй хэмээн тунхагласан манай улсын бодлогод нийцэхгүй.

Тиймээс Монгол Улсын хувьд энэ бүс нутгийн байгууллагын ажиглагч гишүүний статус бүрэн хангалттай байгаа хэдий ч манай улсын сонирхоод байгаа эдийн засгийн хөгжлийг дэмжих томоохон төслүүдэд ажиглагчийн хэмжээнд хамрагдах бололцоогүй нь өөрийн эрх ашигт нийцсэн оролцооны өөр хэлбэрийг бий болгох талаар идэвхтэй ажиллахад хүргэж байна.

ЭШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Qingguo Jia “The Success of the Shanghai Five: Interests, Norms and Pragmatism”.
<http://www.ndu.edu/inss/symposia/pacific2001/jafinal.htm>
2. “Улаанбаатарын тунхаглал”. Гадаад харилцаа мэдээллийн товхимол ГХЯ №2 (126)
3. “НАТО, ШХАБ ба Монгол Улс” дугуй ширээний ярилцлага, ярилцлага хэлэлцүүлгийн тойм. Стратеги Судлал 2004 №2
4. “Гадаад бодлогын үзэл баримтлал”. Төрийн мэдээлэл
5. Chronology of China-Russia Relations /January-March 2003/
<http://www.csis.org/media/csis/pubs/0301q.pdf>
6. Монгол Улсын Гадаад Бодлогын хөх ном 2006 ГХЯ. 2006 УБ
7. http://www.parl.gov.mn/detail.php?pid=24&sid=138&table=parl_detail&id=5733
8. Ерөнхий сайд Москвад... http://www.ubs.mn/www/index.php?action=news.view&news_id=1804
9. ШХАБ-ын гишүүн орнуудын Төрийн тэргүүн нарын Зөвлөлийн хуралдаан дээр Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын хэлсэн үг 2005 http://www.mongolmedia.com/printversion.php?ns_id=94518
10. Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаярын “ШХАБ-ын төрийн тэргүүн нарын зөвлөлийн уулзалтад хэлсэн үг”. 2006
http://www.president.mn/show_module.php?index=speech&speechid=96

11. Ц.Мөнх-Оргил. “Монгол Улсын Засгийн газрын гадаад бодлого уламжлал ба шинэчлэл”. *Олон улс судлал* №1 2005, мөн *Гадаад харилцаа* мэдээллийн товхимол ГХЯ №5 (159) 2005
12. В.Путин: Хамгийн гол амжилт нь Оросын төрийг бэхжүүлсэн явдал 2006.09.14 <http://www.origo.mn/index.php?z=0/0/2521/86/>
13. В.Путин “ШХАБ бол олон улсын хамтын ажиллагааны шинэ хэв загвар мөн”. Өнөөдөр сонин 2006 оны 6 дугаар сарын 15 №138 (2792)
14. Turner, Jefferson: 2005 “What is Driving India’s and Pakistan’s Interest in Joining the Shanghai Cooperation Organization?” *Strategic Insights*, Volume IV, Issue 8 (August 2005) <http://www.ccc.nps.navy.mil/si/2005/Aug/turnerAug05.pdf>
15. З.Пагмажав, “Орос-Хятадын гэрээ хэлэлцээрийн эмхтгэл” Хоёрдугаар хэсэг /1949-2003 он/ УБ, 2003
16. Ардын эрх 1994: “Монгол Улсын Гадаад бодлогын үзэл баримтлал”. №146
17. Монгол, Хятадын хамтарсан мэдэгдэл. “Гадаад харилцаа” №8 (132), 2003
18. Roger McDermott “China advances its interests in Asia through SCO”. <http://www.isn.ethz.ch/news/sw/details.cfm?ID=15537>
19. Эрик Мак-Глинчи. “Түнш үү?, Садаа юу? ШХАБ-ын талаарх АНУ-ын хандлага”. *Стратеги Судлал* №1 2006
20. Regulation on the status of Observer to the Shanghai Cooperation Organization http://russia.shaps.hawaii.edu/fp/russia/2004/20040621_sco_observer.html